



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1961 оны 6 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 327

Улаанбаатар
хот

Улаанбаатар хотод морин
тээврийн баз байгуулах
тухай.

Б Н М А Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Улаанбаатар хотод байгуулагдах 300 морин тэрэгтэй морин тээврийн базыг өөрийн харьяа ботинын авто тээврийн баз, худалдааны трестүүдийг үйлчлэх авто тээврийн базыг түшиглүүлж, хоёр тасаг болгон, энэ оны 8 дугаар сарын 1-нээс эхлэн байгуулахыг Улаанбаатар хотын ардын-депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа /н. БАТАА/-д зөвшөөрсүгэй.

2. Морин тээврийн базад шаардагдах хоронгийн тооцоог хянан үзэж, зохих хөрөнгийг Сайд нарын Зөвлөлийн бэлтгэл хөрөнгөнөөс Улаанбаатар хотын ардын-депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанд олгохыг Сангийн Яам /н. ДҮГЭРСҮРЭН/-д даалгасугай.

3. Морин тээврийн базын тасгуудын орон тоог хянан үзэж, батлаж өхийг Улсын орон тооны комисст даалгасугай.

4. Шинээр байгуулагдах морин тээврийн базын тасгуудад эрүүл бөгөөд эдэлгээнд сургагдсан, 5-6 насны, ажлын чадалтай эрлийз морь 80, монгол морь 155-ыг хотын ойролцоох сангийн аж ахуйнуудаас энэ оны 7 дугаар сарын 30-ны дотор шилжүүлэн өхийг Сангийн аж ахуйнуудыг удирдах газар /н. ЛООХУУЗ/-д даалгасугай.

5. Морин тээврийн базын тасгуудад тэрэгний гол төмөр-380 ширхэгийг энэ оны 7 дугаар сарын 30-ны дотор бэлтгэж өхийг Аж Үйлдвэрийн Яам /н. ДАМДИН/-д даалгасугай.

6. Морин тээврийн баазын тасгуудад шаардагдах 300 морин тэрэгний арал, тоног хэрэгсэл зэргийг энэ оны 8 дугаар сарын 1-ний дотор бэлтгэн, угсарч өхийг Үйлдвэрийн Хоршооллын Төв Зөвлөл /н.ДЭМЧИГ/-т даалгасугай.

7. Морин тээврийн баазын тасгуудад зориулан, „Авто нефть импорт“ нэгдэлд байгаа „ГАЗ-АА“ машины резин дугуй 650 шир-хэгийг зохих үнээр нь Улаанбаатар-хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанд шилжүүлэн өхийг Гадаад Худалдааны Яам /н.ГОМБОЖАВ/-т даалгасугай.

8. Морин тээврийн баазын ачаа тээврийн хөлсний тарифийг боловсруулан батлаж, энэ оны 8 дугаар сарын 15-наас мөрдүүлэхийг Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа /н.БАТАА/-д даалгасугай.

Б.Н.М.А. Улсын Сайд нарын
Зөвлөлийн I-р орлогч дарга

МОЛОМЖАМЦ

Б.Н.М.А. Улсын Сайд нарын
Зөвлөлийн Хэрэг эрхлэх
газрын I-р орлогч дарга

ЦЭРЭНЖАВ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн
эрхлэгч

ДАГВАДОРЖ



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын

Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1961 оны 6 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 330

Улаанбаатар
хот

Улаанбаатар хотын төв паркийн
захиргааг байгуулах тухай.

Б Н М А Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Улаанбаатар хотын төв паркийн захиргааг 1961 оны 6 дугаар сарын 25-наас эхлэн, Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны харьяанд байгуулсугай.

2. Улаанбаатар хотын хүүхдийн паркийг залуучуудын хүчээр байгуулан тохижуулах тухай Монголын Хувьсгалт Залуучуудын Зөвлөлийн Төв Хорооны санаачлагыг сайшаан дэмжсүгэй.

3. Улаанбаатар хотын төв паркийн захиргааны орон тоог хянан батлаж өхийг Улсын орон тооны комисст даалгасугай.

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн I-р орлогч дарга

МОЛОМЯМЦ

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн Хэрэг эрхлэх
газрын I-р орлогч дарга

ЦЭРЭНЖАВ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн
эрхлэгч

ДАГВАДОРЯ